



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Г ХХХVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ Г

Улсын онцгой комиссын хурлыг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 18:00 цагт Төрийн ордон дахь “Орон нутгийн удирдлага”-ын танхимд 93.7 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын нөхцөл байдлын мэдээлэл;

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

- Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах эсэх тухай;

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын өрөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян,

- Улсын онцгой комиссын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл”-ийн мэдээлэл /Гадаад улс орноос ирсэн иргэнийг тусгаарлах байр болон гэрт нь тусгаарлах хугацаанд өөрчлөлт оруулах талаар/;

АШУҮИС-ийн захирал, доктор, профессор Л.Хүрэлбаатар,

- “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийн танилцуулга;

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай,

- Тусгай үүргийн нислэгээр Монгол Улсын иргэдийг татан авах, Гадаад улс оронд санхүүгийн хүнд байдалд орсон Монгол Улсын иргэдэд дэмжлэг үзүүлэх тухай;

Гадаад харилцааны яамны
Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

6. Монгол, Оросын хилийн Алтанбулаг боомтыг түр хаасан хугацаанд тус боомтоор эм, эмийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх нөхцөл боломж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;

Гадаад харилцааны яамны
Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

7. Уул уурхай хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг болон ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн олборлогч аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ээлж солих зохион байгуулалтын арга хэмжээний тухай;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндөн

8. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбаян,

Архангай, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарт нарт:

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас мөн оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаагаар сунгах;

1.2. Архангай аймгийн Батцэнгэл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг сумдын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06:00 цагаас мөн оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаагаар сунгах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбаян,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай,

Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Захирал Д.Нямхүү нарт:

2.1. Улсын онцгой комиссын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл”-ийн зөвлөмж, мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн коронавируст халдварт бүртгэгдсэн гадаад улс орноос ирсэн эмнэлзүйн шинж тэмдэггүй иргэдийг “КОВИД-19”-ийн шинжилгээнд үндэслэн тусгаарлах байранд мэргэжлийн байгууллагын хяналтад 14 хоног, өөрийгөө гэрээр /зочид буудал/ тусгаарлан ажиглах хугацааг 7 хоног болгож тус хугацаанд гурав дахь шинжилгээг авч байхаар холбогдох журамд өөрчлөлт оруулах;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга

Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабт:

3.1. Тусгай үүргийн Франкфуртын нислэгийг 2020 оны 12 дугаар сарын 16, Токиогийн нислэгийг 2020 оны 12 дугаар сарын 20, Сөүлийн нислэгийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд үйлдэж, 2020 оны 11 дүгээр сарын нислэгт нэрс нь баталгаажсан боловч нислэг нь цуцлагдсан Монгол Улсын иргэдийг үргэлжлүүлэн татан авах ажиллагааг зохион байгуулах;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасурэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга нарт:

4.1. Монгол, Оросын хилийн “Алтанбулаг” автозамын боомтыг Засгийн газрын 172 дугаар тогтоолоор түр хаасан хугацаанд Европын орнуудаас эм, эмийн бүтээгдэхүүн тээвэрлэн ОХУ-ын “Хиагт” боомтод Тир конвенцын дагуу ирсэн болон ирэх авто машинуудыг “Алтанбулаг” автозамын боомтоор халдварт хамгааллын онцгой дэглэмийн дор улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэсэн ачааг хүлээн авах, эцсийн цэгт хүргэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх;

4.2. Хилийн Алтанбулаг боомтоор Европын орнуудаас эм, эмийн бүтээгдэхүүн тээвэрлэн ирэх автомашиныг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийг дуустал нэвтрүүлэх;

Тав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндөн,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга нарт:

5.1. Уул уурхай, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч, ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн олборлогч, экспортлогч, тэдгээрийн туслан гүйцэтгэгч, уул уурхай, газрын тосны салбарын үйл ажиллагаанд ажил үйлчилгээ ханганд нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд коронавируст халдварт /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, халдварт, хамгааллын дэглэмийг сахиулах, шинжилгээ өгөх нөхцөлийг бүрдүүлж, ээлж солих ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

5.2. Ээлжээс буух, ээлжид гарах ажилчдыг “КОВИД-19”-ийн шинжилгээнд хамруулж, шинжилгээний хариуг үндэслэн Улаанбаатар хот болон орон нутагт нь иргэдтэй хавьтал үүсгэхгүйгээр хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах;

5.3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журмыг шинэчлэн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;


Зургаа. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Аймгийн Засаг дарга, онцгой комиссын дарга нарт:

6.1. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу аймаг, нийслэлийн түвшинд коронавируст халдварт /КОВИД-19/-ын хүн амын дунд тархах эрсдэлийн дараагийн шатны үнэлгээг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн дотор хийж, орон нутгийн одоогийн нөхцөл байдалд эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг хангах;

6.2. Орон нутгийн нислэг сэргээх, нисэх буудлын үйл ажиллагааг дахин эхлүүлэхтэй холбогдуулан үзлэг шалгалт, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллах;

ДАРГА 
Я.СОДБААТАР

НАРИЙН БИЛГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ

